

## Хэн юу хэлж, хийж явааг мэддэг хүн байна уу?

(ТВ25 Цөмийн хаягдлын тухай “Дуусдаггүй Яриа” )

Саяхан буюу 2011 оны 5 сарын 21-ний 20:00 ТВ25-аар гарсан Цөмийн хаягдлын тухай “Дуусдаггүй Яриа” нэвтрүүлэг ширүүхэн болж өнгөрчээ. Тус нэвтрүүлэгт УИХ-ын гишүүн Д. Энхбат, О.Чулуунбат, Л.Гантөмөр, Н.Батбаяр, ГХЯ-ны тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд Ундраа гэх мэт хүмүүс оролцжээ. (Харин чухал хүмүүсийн нэг МонАтомын Бадамдамдин хаана үлдчихэв дээ???)

Цаг гаруй хугацаанд ам уралдан өрсөж ярьсан сонирхолтой нэвтрүүлгийн аудио бичлэгийг сонсох гэвэл энэ линкээр орж <http://www.mediafire.com/?n2bxvclk8dnltt8> татаж авч болно. Удалгүй нэг сайхан сэтгэлтэн YouTube дээр тавьж туслах байлгүй.

Манай эрх мэдэлтнүүд олон удаагийн “но”-той мэдэгдэл хийсний дотор (О. Чулуунбат АЦС-ыг машин, онгоц хэрэглэхтэй удаа дараа зүйрлэж ёстой гайхшруулав) Монголд АЦС барих эсэх нь тодорхойгүй байгаа, барих гээгүй ч юм шиг ярьж будилцаах юм.

### Гэтэл баримт ЮУг өгүүлнэ вэ?

Фукушимагийн ослын дараахан академич Чадраа гэхэд л өдөр тутмын сонинд уран ашиглалт, АЦС-ыг шагшсан 2 том ярилцлага өгч, 4 сарын эхээр АЦС сурталчилсан телевизийн нэвтрүүлэгт оролцож байсан:

2011-03-15—**Б. Чадраа: Бурхнаас бидэнд уран гэгч атомын цахилгаан станцын түлшийг бэлэглэсэн** <http://sonin.mn/?p=121529>

2011-04-18—Өдрийн сонин—**Монгол улс атомын цахилгаан станцгүйгээр хөгжихгүй ээ.** <http://www.medee.mn/content/26734.shtml> (Энэ сурвалжлагаа “Өдрийн сонин” сайтаасаа авчихсан байх юм)

2011-04-07—МонАтомын дэд захирал Г. Цогтсайхан гэгч Ройтерс агентлагийн сурвалжлагчид ярихдаа Японд осол гамшиг болсон ч Монгол улс АЦС барих төлөвлөгөөнөөсөө ухрахгүй гэжээ.

<http://in.reuters.com/article/2011/04/07/mongolia-nuclear-idINL3E7F713C20110407>

Эцэст нь сар гаруйн өмнө Монгол Улсад АЦС барих ажил арванхоёрдугаар сараас эхлэнэ гэсэн мэдээ гарч, Цөмийн Энергийн газрын дарга С. Энхбат Солонгосчуудтай гэрээнд үзгэлсэн гэх....

<http://mobile.news.mn/mcontent/63783.shtml?s=biznes>

<http://www.energy.mn/web/index.php/component/content/article/3-newsflash/211-2011-04-22-01-02-03>

## **ДЭЭГҮҮРХ ХҮМҮҮС ХЭН НЬ ЮУ ХИЙЖ БАЙГААГ МЭДДЭГ ЮМ УУ ???**

Удирдлагагүй онгоцонд суучихсан юм шиг санагдаад явчих чинь.

НЭГ ӨГЛӨӨ босоод харахад хашаанд минь АЦС ажиллаж байх юм биш биз дээ? Бас буланд нь хаягдлаа эвтэйхэн хураачихсан байх вий дээ...